



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/5/3

Мөрөн сум

Согтууруулах ундаа худалдах,
түүгээр үйлчлэх, олныг хамарсан арга хэмжээ
зохион байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.1, 69.1.2, 69.1.3, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулагдах болсонтой холбогдуулан гэмт хэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 оны 10 дугаар сарын 10, 11, 12-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, 2024 оны 10 дугаар сарын 11-ны өдөр соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллуулахыг хориглосугай.

2.Энэ өдрүүдэд архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байхыг иргэн, аж ахуйн нэгжийн захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Биеийн тамир, спортын газрын дарга (Б.Очирбат), Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга (Л.Батцэцэг), хяналт, шалгалтыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Д.Мөнхжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д тус тус даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

